**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 09 өдөр Дугаар А/181 Улаанбаатар хот

**“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”**
**орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн**
**газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 17,019,999.0 (арван долоон сая арван есөн мянга есөн зуун ерэн ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг “Багануур үйлпвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ (Ч.Элбэгсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 960,000.0 (есөн зуун жаран мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 4 нэр төрлийн 16,059,999.0 (арван зургаан сая тавин есөн мянга есөн зуун ерэн ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 95,000.0 (ерэн таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 28,500.0 (хорин найман мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэн, Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг “Багануур үйлпвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ (Ч.Элбэгсайхан)-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1150500671

D: Iac \BL.Tushaal. docx

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

## Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Багануур үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ

/төгрөгөөр/

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | ҮХХХК-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Компьютер Dell | 8 | ком | 3 | 1,080,000.0 | 3,240,000.0 | 3,240,000.0 | 0.0 | Эх хавтан CPU ,чипний гэмтэлтэй | Актлах | 0.0 | 15,000.0 |
| 2 | КомпьютерDell | 8 | ком | 14 | 880,000.0 | 12,320,000.0 | 12,320,000.0 | 0.0 | Эх хавтан CPU ,чипний гэмтэлтэй | Актлах | 0.0 | 70,000.0 |
| 3 | Принтер epson | 8 | ш | 1 | 330,000.0 | 330,000.0 | 330,000.0 | 0.0 | Эвдэрсэн, засвар авах боломжгүй | Актлах | 0.0 | 5,000.0 |
| 4 | Принтер canon | 9 | ш | 1 | 169,999.0 | 169,999.0 | 169,999.0 | 0.0 | Эвдэрсэн, засвар авах боломжгүй | Актлах | 0.0 | 5,000.0 |
| **Машин тоног төхөөрөмжийн дүн** | | | | | | **16,059,999.0** | **16,059,999.0** | **0.0** | | | | |
| 5 | Сандал савхин | 9 | ш | 1 | 560,000.0 | 560,000.0 | 560,000.0 | 0.0 | Эвдэрсэн, түшлэг хугарсан,хөл хугарсан | Актлах | 0.0 | устгах |
| 6 | Сандал | 9 | ш | 5 | 80,000.0 | 400,000.0 | 400,000.0 | 0.0 | Эвдэрсэн, түшлэг, хөл нь хугарсан | Актлах | 0.0 | устгах |
| **Тавилга эд хогшлийн дүн** | | | | | | **960,000.0** | **960,000.0** | **0.0** | | | | |
| **Нийт данснаас хасах хөрөнгийн дүн** | | | | | | **17,019,999.0** | **17,019,999.0** | **0.0** | | | | |
| | | | | | Үүнээс. Худалдах хөрөнгө | **16,059,999.0** | **16,059,999.0** | **0.0** | | | | |
| | | | | | Актлах хөрөнгө | **960,000.0** | **1,459,999.0** | **0.0** | | | | |
| | | | | | Татан төвлөрүүлэн хөрөнгө | **0.0** | **0.0** | **0.0** | | | | |
| | | | | | Худалдсанаас олох орлого | **95,000.0** | | | | | | |
| | | | | | НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | **28,500.0** | | | | | | |